



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэхь хэсэг 4.2.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 7 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын
13-ны өдрийн *1/2* тоот тушаалын хавсралт



1. "Азиа Пасифик Секьюритис ҮЦК" ХХК
2. "Гендекс ҮЦК" ХХК
3. "Дэлгэрхангай Секьюритиз ҮЦК" ХХК
4. "Зэт Жи Би ҮЦК" ХХК
5. "Масдак ҮЦК" ХХК
6. "Монгол Секьюритиес ҮЦК" ХК
7. "Нэйшнл Секьюритис ҮЦК" ХХК